



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Г “Мүдикс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой 7 хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авах саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мүдикс” ХК-ийн нийт 82,417 ширхэг гаргасан хувьцааны 43,99 хувь буюу 36,262 ширхэг хувьцааг нэгдмэл сонирхолтой этгээд болох “Трансцент капитал менежмент” ХХК, Япон улсын иргэн Хаята Окомото, Масака Окамото, Эми Окамото нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 56,1 хувь буюу 46,155 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 544 /таван зуун дөчин дөрөв/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээд /“Трансцент капитал менежмент” ХХК/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН